



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/46

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "б", 29.1.6 "а" заалт Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 20 дугаар тогтоолын 2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Үндэсний хөгжлийн газрын дарга болон аймгийн Засаг даргын хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгийн хөгжлийн индекс тооцож, мэдээллийн нэгдсэн санг тогтмол мэдээллээр хангах үүрэг бүхий байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: А.Мөнхтуяа (Боловсрол соёл урлагийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Бат-орших (Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Энхтуяа (Статистикийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ж.Уянга (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Хоёр. Хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан "Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн системд"-д оруулан баталгаажуулж байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр хангаж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210090